



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 573

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.2, 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Завхан-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид сэргээн засварлах боломжгүй болсон 343,531,464.37 (гурван зуун дөчин гурван сая таван зуун гучин нэгэн мянга дөрвөн зуун жаран дөрвөн төгрөг гучин долоон мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий машин механизмыг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. “Завхан-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал М.Болдод дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих захиргааны актын дагуу дуудлага худалдааг зохион байгуулах зардлыг хассан дүнгээр байгууллагын дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д оруулан бүртгэх;

2.4. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б. ГАВАА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн
823 дугаар тогтоолын хавсралт

**"Завхан-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах автомашин**

д/д	Автомашинь марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Ашиглалтад орсон огноо	Нийт гүйлт (км)	Балансын үнэ (төгрөгөөр)	Хуриятлагдсан элэгдэл (төгрөгөөр)	Үлдэх өртөг (төгрөгөөр)	Сэргээн босголтын зардал (төгрөгөөр)	Худалдах доод үнэ (төгрөгөөр)
1	Маяти маркийн кран, УБТ16-75 УБТ улсын дугаартай, Арлын дугаар -С3600	2009/01/01	5 35.00	8,500,0 00.00	8,500,0 00.00	0.00		500,000.00
2	Пажеро 4 маркийн кран, УБИ 28-84 улсын дугаартай, Арлын дугаар -V75W0100472	2007/04/01	906258	18,778,0 76.00	18,778,0 76.00	0.00		500,000.00
3	Чиргүүл Cat	2004/01/01		600,0 00.00	600,0 00.00	0.00		
4	ISUZU маркийн өөрөө буулгагч, ЗАА93-15 улсын дугаартай, арлын дугаар-37000024	2004/01/01	312327	50,135,1 94.00	50,135,1 94.00	0.00		1,000,000.00
5	ДЗ-122 маркийн автогрейдер, арлын дугаар-178895	1983/03/01		6,197,9 95.80	6,197,9 95.80	0.00		300,000.00
6	ДЗ-122 маркийн автогрейдер, 57-12 УБ улсын дугаартай, арлын дугаар-69739722	2004/01/01		49,182,0 00.00	49,182,0 00.00	0.00		500,000.00
7	ДЗ-180 маркийн автогрейдер,	1980/01/01		49,890,8 83.15	49,890,8 83.15	0.00		500,000.00
8	Бульдозер, ЗАА 47-14 улсын дугаартай, арлын дугаар- 833955	2/1/1983		5,000,0 00.00	5,000,0 00.00	0.00		300,000.00
9	Dong Feng маркийн камаз, 84- 70 УБ улсын дугаартай,	2010/12/01		15,000,0 00.00	15,000,0 00.00	0.00		1,000,000.00
10	WZ маркийн экскаватор, 30-25 УБ улсын дугаартай, арлын дугаар-1009J013	2009/01/01	92000	60,753,7 00.00	60,753,7 00.00	0.00		500,000.00

11	ДУ-16 маркийн индүү, ЗАА 41-90 улсын дугаартай, арлын дугаар-29850	1994/01/01	956814	20,614,5 64.42	20,614,5 64.42	0.00		300,000.00
12	CAT-438 маркийн экскаватор, 57-21 УБ улсын дугаартай, арлын дугаар-300928	2004/01/01	25007	58,879,0 51.00	58,879,0 51.00	0.00		300,000.00
				343,531,464.37	343,531,464.37	0.00	0.00	5,700,000.00
	нийт хөрөнгийн дүн			343,531,464.37 (гурван зуун зөчин гурван сая таван зуун гучин нэгэн мянга дөрвөн зуун жаран гучин долоон мөнгө)	343,531,464.37 (гурван зуун зөчин гурван сая таван зуун гучин нэгэн мянга дөрвөн зуун жаран дөрвөн төгрөг гучин долоон мөнгө)			5,700,000.00 (таван сая долоон зуун мянган)